

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ

3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. ТӨРИЙН УДИРДАЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу 2018 оны яамдын сайдтай байгуулсан гэрээний биелэлт, байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлын биелэлт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлтийн тайланг нэгтгэж хяналт-шинжилгээ хийн үнэлгээ өгч Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 3 дугаар сарын 19-ний 9/360 тоот албан бичгээр хүргүүлээ.

Мөн Засгийн Газрын хэрэг эрхлэх газарт 2018 оны Хяналт-шинжилгээ, үнэлгээний бичмэл тайлан, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хасах санал, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн 1-р улирлын тайланг <http://unelgee.gov.mn/> цахим хуудсанд оруулж, тайланг хүргүүлсэн ба Монгол улсын Ерөнхий сайдын орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөний үеэр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 1-р улиралын биелэлийг гаргаж хүргүүлээ.

Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд албан хаагчдыг МУЗГ-ын төлөвлөгөөт зайны болон танхимын сургалт, өөрийн хариуцсан ажлын чиглэлийн уулзалт, зөвлөгөөн, хуралд бүх шатны албан хаагчдыг бүрэн хамруулж байна.

Онцгой байдал, гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх талаар:

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Улсын Онцгой комиссын “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 01 албан даалгаврын дагуу аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгавр гаргасан ба Онцгой байдлын газрын даргын 2019 оны 32/68, 32/69, 32/70, дугаар албан бичгүүдийг сумдад хүргүүлээ. Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бүх талын арга хэмжээг авч, сайн дурын хэсэг, гал түймэр унтраах 1, 2, 3 бүлгүүдийг томилгоожуулан нийт 13 сумын 39 бүлгийн 419 хүний үүрэг гүйцэтгэх, албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлыг ханган, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгоод байна. Мөн аймгийн Засаг даргын “Гамшгаас хамгаалах сургууль, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг, гамшгаас хамгаалах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх шалгалт зохион байгуулах тухай” 2019 оны А/75 дугаар захирамж гаргуулан сумдад ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, ОБЕГ-ын тэргүүн дэд дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, мэргэжлийн удирдлага, шуурхай зохион байгуулалтаар хангах, төр, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар аймагт ажиллаж аймгийн Онцгой комиссыг хуралдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, авч буй арга

хэмжээний талаар мэдээлэл сонсож, тулгамдаж байгаа асуудлыг газар дээр нь шийдвэрлэж холбогдох санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.

Аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Т.Энхбаатар, болон холбогдох албаны мэргэжилтнүүд 03 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга сумдад ажиллаж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцан, Улсын онцгой комиссын болон аймгийн Засаг даргын албан даалгаврыг хэрэгжүүлэх, ажлаа нарийн төлөвлөн хамрах цар хүрээг нэмэгдүүлж, хүн хүч, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг сумын Онцгой комиссын дарга болон холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болголоо.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг зохион байгууллаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, мэдлэг чадварыг олон нийтэд олгох зорилгоор GARITAS монгол олон улсын байгууллагатай хамтран ард иргэд, олон нийтэд “Бэлэн бай” сургалтыг Дарьганга, Онгон сумдад 3 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан 2 сумын 130 хүнд гамшиг, осол болон гамшгийн эрсдэлийг бууруулах талаар иргэдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, хувь хүн болон өрхийн бэлэн байдлыг хангах, болзошгүй гамшиг, ослын үед өөртөө болон нөхрөө аврах, анхны тусламж үзүүлэх, амилуулах суурь тусламж үзүүлэх, орон нутгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох дэмжлэг үзүүлэх дадлыг эзэмшүүлсэн. Мөн сургалтын үеэр иргэд олон нийтэд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, “Сайн дурын хэсэг”-ийн ажиллах журам, зааврийн талаар хууль, эрхзүйн мэдээлэл өглөө.

Онцгой байдлын ерөнхий газар болон Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс ирсэн урьдчилан сэргийлэх, цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг SMS SENDER IRS программ скайтелийн 3G модемийг ашиглан цаг алдалгүй АОК гишүүд болон, сумдын тамгын газрын дарга нар, хөдөөний багуудын малчин өрхүүдэд багц мессэжийн үйлчилгээг ашиглан 4 удаа 12 сумын, 5208 хүнд цаг алдалгүй түргэн шуурхай хүргэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, анхааруулах сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор ОБЕГ, Ус цаг уур орчны шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн урьдчилан сэргийлэх цаг агаарын мэдээг орон нутгийн 2 телевизээр нийт 32 удаа хүргээд байна. Онцгой байдлын газрын www.Sukhbaatar.uridchilansergiileh facebook хаягаар иргэдэд цаг үеийн мэдээллийг 13 удаа хүргэн ажиллалаа.

Мөн орон нутгаас хэвлэгдэн гардаг Сүхбаатарын өнгө сонинд урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг болон тухайн үеийн мэдээ, мэдээллийн талаар 8 удаа нийтлүүлээд байна.

Сүхбаатар сумын “Ланз” багийн “Жаргалант” гэдэг газар /сумын төвөөс урд зүгт 50 км, аймгийн төвөөс урд зүгт 80 км-т/ хээрийн түймэр гарсан тухай 2019.03.03-ны өдрийн 12:30 цагт хүлээн авч дуудлагаар ЭХАС-ын нэг бүлгийн 12 алба хаагч ажилласан.

Гал унтраах тактик, тархалтын сургуулийн төлөвлөгөөний дагуу тактикийн сургуулийг “Ган-Эрдэнэ”, “Баялагын ундрах”, “Жаахан шарга” хөгжимт жүжгийн театр, “Үндэсний угсаатны зүй музей” зэрэг нийт 4 байгууллагуудад Урьдчилан сэргийлэх тасаг, Эрэн хайх аврах салбартай хамтран тархалтын сургуулийг дадлага ажил болон танхимаар зохион байгуулж, байгууллагын алба хаагчдад гал унтраагуур ажиллуулах талаар дадлага сургууль хийлээ. Сургалтад аж ахуй нэг байгууллагаас 85 хүн хамрагдаж Онцгой байдлын албанаас давхардсан тоогоор 32 албан хаагч оролцлоо.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/314 дугаар тушаалаар батлагдсан “Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах” журмын хүрээнд ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд хэрхэн ажиллах, хээрийн гал түймэртэй тэмцэх автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор хээрийн гаралт зохион байгууллаа. Өгөгдсөн цэг дээр хээрийн түймэр унтраах дадлага сургалтыг зохион байгуулж, унтраах ажилд хээрийн түймэр унтраах зориулалттай автомашиныг бүрэн хүчин чадлаар ажиллуулж, алба хаагчид үлээгч аппарат, тороосон шүүр, цохиураар унтраах дадлага сургуулийг зохион байгуулж ажиллалаа. Мөн жолооч нараар хээрийн түймэр унтраах автомашиныг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах дадлага хийлгэж, аврагч, гал сөнөөгчид нь үлээгч аппараттай ажиллах, гэмтэл гарсан үед хэрхэн засвар үйлчилгээ хийх, Шуурхай удирдлагын оператор, холбоочин, жолооч нар гамшиг осол болон хээрийн түймрийн үед холбоо хэрхэн зохион байгуулах талаар сургалт зохион байгууллаа.

Сүхбаатар аймгийн хэмжээнд гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллалаа.

МУ-ын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоол, 2011 оны 339 дүгээр тогтоол “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоол “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-ын дагуу 3 дугаар сарын 21-ний өдрийн 16:00 цагт аймгийн “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ны барилга дээр байрлах дуут дохио, Зэвсэгт хүчний 338-р ангийн дуут дохио, аймгийн “Дөрвөлж” толгой, 2-р багийн нутаг буюу баруун хойд чиглэл, Замын цагдаагийн тасгийн тусгай зориулалтын тоноглолтой 2 автомашин, Гал түймэр унтраах, аврах 15 дугаар ангийн тусгай зориулалтын дуут дохиотой 2 автомашиныг маршрутын дагуу 4 чиглэлд хөдөлгөөнт байдлаар тус тус зарлан мэдээллийн дохиог Баруун-Урт сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгэн зэрэг дамжуулан зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа. Зарлан мэдээллийн дохиогоор аймгийн төвд Аймгийн онцгой комиссын гишүүд, албад, мэргэжлийн анги, уул уурхайн албаны бүрэлдэхүүн техник хэрэгслийг нэгтгэн байршуулж хувцасны жигдрэлт, аранз, машин техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг Аймгийн удирдлагууд шалган зааварчлага, үүрэг чиглэл өгч ажиллалаа. Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрийн төвийн сурагч, багш, ажилтан албан хаагчдад ЗГ-ын 339, 340, 67 дугаар тогтоол “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийн хүрээнд “Газар хөдлөлт” сэдвээр танхимын болон гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллуулах дадлага, сургуулийг урьдчилсан байдлаар зохион явуулсан. Зарлан мэдээллийн дохиогоор гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангийн 352 хүн, 25

автомашин, техник хэрэгсэл, сургууль цэцэрлэгийн хүүхэд 2877, 265 багш ажилчид, 13 сумын хэмжээнд 65 автомашин 2107 хүн, 90 техник хэрэгсэл, 6076 хүн цугларч зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургалтад оролцсон байна.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор баталсан "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх" таниулах өдөр-ийн хүрээнд 2018 оны 03 дугаар сарын-18-ны өдөр Дөрвөлж /ОНӨҮГ/-ын 23 мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, 03 дугаар сарын 19-ны өдөр 67 ажилчдад "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх", эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор танхимын сургалт зохион байгуулсан. Мөн

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг 2019 оны 03 дугаар сарын 19-ны өдөр Сүхбаатар аймгийн "Хөгжимт жүжгийн театр"-ын бага танхимд 15:00 цагт зохион байгуулж ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Б.Ууганбаярын "Газар хөдлөлтийн үед ямар арга хэмжээ авах вэ", Газар хөдлөлтийн гамшигт бэлэн байдлаа хангадаг хариуцлагатай иргэн бэлтгэх нь" сэдэвт теле хичээлийг хүргэлээ.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн төсвийн орлого санхүүжилтийг хууль, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлгээр 473,8 сая төгрөг, хандиваар 45,0 сая төгрөг, улсын төсвөөс 3300,6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч орон нутгийн төсөвт 1280,1 сая төгрөгийн орлого орж, орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 2807,1 сая төгрөг хугацаандаа хийгдлээ. Үүнээс сумдад санхүүгийн дэмжилгээр 644,8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал 1054,8 сая төгрөг, соёлын шилжүүлгийн байгууллагуудад 466,3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлгээр 1877,1 сая төгрөг, Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгээр 3677,7 сая төгрөг, Газрын харилцаа кадастрын тусгай зориулалтын шилжүүлгээр 87,3 сая төгрөг, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгээр 1020,6 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн байна.

Өдөр тутмын төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог түргэн шуурхай хийж, банк хооронд дамжуулан ажиллаж байна.

Аймгийн Татварын хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Төрийн аудитын газартай хамтран 3 дугаар сарын 1-ны өдөр сумын төсвийн шууд захирагч нар, сумын ЗДТГ-ын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч нарт төсвийн байгууллагын өдөр тутамын төлбөр тооцоо, тайлан мэдээ, илэрч буй зөрчил дутагдал, анхаарах асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг зэргийг тодорхойлсон сургалтыг зохион байгуулж 125 хүнийг хамрууллаа.

Худалдан авах ажиллагааны талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 03 дугаар сарын 04-ний өдрийн А/104 тоот захирамжаар шинэчлэн

баталлаа. Уг төлөвлөгөөнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2779,9 сая төгрөгний 43 бараа, ажил, үйлчилгээний тендер тусгагдсанаас 3 дугаар сарын байдлаар тендер нь зарлагдаж гүйцэтгэгч нь шалгарсан 3, хүлээж авах хугацаа болоогүй 2 тендер байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14480,1 сая төгрөгийн 13 ажил эрх шилжиж ирсний “Хүнсний ногооны зоорь”-ийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/-ын тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлаад байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газартай хамтран 3 дугаар сарын 11-12-ны хооронд хөрөнгө оруулалтыг төлөвлөхөөс эхлээд хүлээж авах хүртэлх процессын үйл ажиллагааны хүрээнд 3 талт сургалтыг 13 сумын 57 албан хаагчдад онолын болон дадлага ажил бүхий сургалтыг зохион байгууллаа.

2019 оны 03 дугаар сарын 21-23-ны хооронд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А/3 сургалт зохион байгуулагдсан ба 89 хүн хамрагдсанаас 60 хүн тэнцэж үнэлгээний хороонд суух эрхтэй болсон.

Өмчийн бүртгэл, хяналтын талаар:

Орон нутгийн өмчит 14 байгууллагаас үндсэн хөрөнгийн талаар ирүүлсэн санал хүсэлт, холбогдох материалыг судлан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах, актлах, шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай 4-н тогтоол гаргуулан, хяналт тавин ажиллаж байна. Мөн “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг батлууллаа.

Дуудлага худалдааг 1 удаа зохион байгуулж нийт орон нутгийн төсөвт 21,900,000 /Хорин нэг сая есөн зуун мянган/ төгрөгийг төвлөрүүлсэн.

Орон нутгийн өмчит 140 хуулийн этгээдийн 2018 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг мэдээг байгууллага, сумдаар тулган баталгаажуулах ажил хийгдэж байна.

Статистикийн талаар:

Статистикийн сарын мэдээ тайланг хүлээн авч, нэгтгээд байна.

13 сумын Засаг дарга, хүн ам зүйн түшмэл, 67 багийн Засаг дарга нарт 3 дугаар сарын 06-ны өдөр Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого, байшин орон, сууцны 2019 оны тооллогын талаар мэдээллийг өгч, бэлтгэлийг ханган ажиллах талаар чиглэл өгөх 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газраас хамтран зохион байгуулсан “Аймгийн хөдөө аж ахуйн салбарын удирдах ажилтан, мэргэжилтний зөвлөгөөн”-нд сумын Засаг дарга нар, мал үржлийн тасаг, хувийн хэвшлийн дарга, эрхлэгч, малчдын иргэдийн төлөөл нийт 130 гаруй хүн оролцсон бөгөөд энэхүү зөвлөгөөнд хөдөө аж ахуйн салбарын мэдээ, тайлангийн гаргалт, чанар, хамрах хүрээ болоод уялдаа холбоог сайжруулах талаар мэдээлл өглөө.

Өрхөд суурилсан өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаануудын 3 дугаар сарын мэдээллийг сонгогдсон 6 сумын 9 нэгжийн 86 өрхөөс цуглуулж, хянаж нягтлан Үндэсний статистикийн хороонд хүргүүлээд байна.

Хяналт шалгалтын талаар:

2019 оны 1 дүгээр улиралд Сангийн сайдын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Нийгмийн даатгалын сангууд, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг, иргэн хуулийн этгээдийн хүсэлт, гомдлоор аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дөрвөлж ОНӨААТҮГ, Сүхбаатар сумын ОНХСан, БЭМСангийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, Сүхбаатар Үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус нийт 9 хяналт шалгалтыг хийлээ.

Хяналт шалгалтаар 8 удирдамж боловсруулж, 7-н танилцуулга үйлдэн, улсын ахлах байцаагчийн 11 актаар 97.3 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 668.1 сая төгрөгийн зөрчилд, зөрчлийг арилгуулах 4-н албан шаардлага хүргүүлж, 4-н дүгнэлт гаргалаа. Нийт төлбөрийн 39.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 53.3 сая төгрөгийг тухайн байгууллагад, 4.2 сая төгрөгийг иргэнд олгуулахаар тогтоолоо.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Уул уурхайн талаар:

“Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа 2019” уул уурхайн зөвлөгөөн зохион байгууллаа.

3 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын А/62 дугаар захирамжийн дагуу “Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа 2019” уул уурхайн зөвлөгөөн зохион байгууллаа. Зөвлөгөөнд уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 20 гаруй аж ахуй нэгж, УУХҮЯ, ЗТХЯ, АМГТГ, Автотээврийн үндэсний төвийн холбогдох төлөөлөл, орон нутгийн төрийн байгууллага, сумдын удирдлага, ИНБ, иргэдийн төлөөлөл нийт 140 орчим хүн оролцлоо. Тус зөвлөгөөнөөр уул уурхайн салбарын эрх зүйн орчин, орон нутагт тулгарч буй хүндрэл, цаашид орон нутгаас барьж буй бодлого анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Мөн тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, авто замын засвар арчлалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцсэн ба цаашид аж ахуй нэгжүүд орон нутгийн чанартай авто замаар тээвэрлэлт гүйцэтгэх чиглэлийг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулах, 6 дугаар сарын 1-нээс өмнө зам засварын ажлыг хийж дуусган, тээвэрлэлт хийх шийдвэрийг гаргуулахыг уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгжүүдэд үүрэг даалгавар өглөө.

Мөн Засгийн газрын 179 дүгээр тогтоолын дагуу Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж уурхай ашиглах, үйлдвэр барихтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сайн дурын үндсэн дээр орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулах ажлыг эхлүүлж аймгийн Засаг дарга, сумын

Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч 7 ААН-тэй хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулаад байна.

Аймгийн Засаг даргын 2014 оны А/446 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 3 дугаар сарын 14-16-ний өдрүүдэд Эрдэнэцагаан, Сүхбаатар сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Андын Илч” ХХК, “Бадмаараг хаш” ХХК, “Нагааранз” ХХК, “Премиум көүл” ХХК-иудын олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт дүгнэлт өгч ажиллаа.

Зам тээврийн талаар:

Баруун-Урт сумын төвийн 2, 3-р багт баригдах 800м хатуу хучилттай авто замын зураг төсөл, төсөвт өртгийн тооцоо боловсруулах, зөвлөх үйлчилгээний тендерийн шалгаруулалт хийгдэж, гүйцэтгэгчээр “Ростов” ХХК шалгарсан ба гэрээ байгуулаад байна.

Хүнс, хөдөө аж ахуйн талаар:

"Хүн бүрийн оролцоог дэмжсэн бүтээлч ажлын жил-2019" уриан дор ХХАА-н салбарын удирдах ажилтан, мэргэжилтэн, тариалан эрхлэгчдийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд “Ургамал хамгаалал” эрдэм шинжилгээний хүрээлэн, ШУТИС-ийн ТАНА лабораторийн багш эрдэмтэн доктор, 13 сумын мэргэжилтэн 120 гаруй иргэн ААН оролцож ШУ-ны үндэслэлтэй технологи шингээсэн үр ашигтай үйдвэрлэл, ЖДҮ-ийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, мэргэжлийн арга зүй зөвлөгөө өглөө. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, сумын Засаг дарга, МЭҮТ-тай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд МСҮТ, ХХҮГ хамтран Газар тариалан-Эрчимжсэн мал аж ахуйн мэргэшсэн ажилтан бэлтгэх ангийг нээн хичээллүүлж байна.

УХЭШХүрээлэнтэй хамтран Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Онгон, Наран сумдад усны тархалтын тодотгосон судалгааг хийлээ.

7 хоног бүрийн 4 дэх өдөр сумдаас мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг авч ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон МҮБХЗ газарт явуулаад байна. Тус аймгийн хэмжээнд 3 сарын 27-ны байдлаар 130573 эх мал буюу 7.9 хувь нь төллөж гарсан төлийн 99% нь бойжиж байна. Нийт 3414 том мал зүй бусаар хорогдсон ба энэ нь нийт мал сүргийн 0.09 %-ийг эзэлж байна.

Ноолуур самналтын явцын аймгийн хэмжээнд 48%-тай байлаа. Хамгийн бага нь Онгон 5%, Дарьганга 7% бусад нь 40-60% тай байсан.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу тус аймгийн Түмэнцогт суманд үржүүлж буй Дорнод талын махны хэвшлийн үхрийг үүлдрээр батлуулах талаар Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, Хөдөө аж ахуйн газар болон Дорнод талын махны хэвшлийн үхрийн авторууд, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэдтэй уулзалт хийж үүлдэр батлуулах, ажлын төлөвлөгөө, шаардагдах төсөв болон үүлдрийн тодорхойлолтыг бичиж эхлүүлэн аймгийн Засаг даргын захирамжаар үүлдэр батлуулах ажлын хэсгийг томилоод байна.

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний талаар:

Ноолуурын дуудлага худалдаа зохион байгуулаа.

Хөдөө аж ахуйн бирж, ХХААХҮЯ-наас малчид, хоршоодыг арилжаанд шууд оролцуулах, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, ноолуурын зах зээлийн бодит үнэ тогтоох зорилгоор ноолуурын төвлөрсөн дуудлага худалдааг 3 дугаар сарын 22, 23-нд аймгийн төвд зохион байгууллаа. Энэхүү төвлөрсөн худалдаагаар нэг кг ноолуурын үнэ 133.0 мянган төгрөгөөр тогтож 20 гаруй тонн арилжигдсан байна. Худалдагч болон худалдан авагчдыг нэг дор төвлөрүүлж бодит үнэ тогтоосон нь малчдын орлогыг нэмэгдүүлж, худалдан авагчдын эрэлтийг хангасан худалдаа боллоо.

Хоол үйлдвэрлэлийн салбарын ажилчдыг чадваржуулах ажлуудыг зохион байгууллаа.

Мэргэжлийн боловсролын сургалтын үнэлгээний төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд байгуулагдсан бөгөөд хоол үйлдвэрлэлийн мэргэжилтэй ажилтны мэргэжлийн ур чадвар, хандлагыг олон улсын жишигт ойртуулан үнэлэх ажил хийж эхлээд байна. Энэхүү ажлын хүрээнд тогооч, мэргэжлийн ажилтнуудын /Цэцэрлэг, сургууль, эмчилгээ, сувиллын хоол, зоогийн газар, рестораны тогооч/ онолын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилдээ хандах хандлагыг өөрчлөн сайжруулах зорилгоор шинэ нэр төрлийн жор, технологи болон онолын мэдлэгийг сайжруулах 3 хоногийн сургалтыг Монголын тогооч нарын холбоо, Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөл хамтран зохион байгуулж, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын 30 гаруй ажиллагсад, тогооч нар хамрагдлаа. Мөн Дарьганга сумын хоол үйлдвэрлэлийн салбарын 10 тогоочид 5 хоногийн сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгож, 4 тогоочийн зэргийг ахиуллаа. ХХААГ, сумдын ХАА-н тасагтай байгуулсан гэрээнд тусгагдсан Сумын аварга тогооч, зөөгч шалгаруулах уралдаан, хоолны үзэсгэлэнг Дарьганга, Түмэнцогт сумдын ЗДТГ газар зохион байгуулсан.

Мал эмнэлэгийн салбарын ажилчдын сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, урьдчилан сэргийлэх ванцинжуулах ажил хийгдэж байна.

Аймгийн Засаг даргын А/38 дугаар захирамжаар гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 8 суманд хийхээр 229 удирдах ажилтан, малын эмч, туслах ажилтанаас бүрдсэн 49 ажлын хэсэг ажиллаж байна. Нийт 1,7 сая мал хамрагдахаас одоогийн байдлаар 1,6 сая мал хамрагдаж ажлын явц 95,8 хувьтай байна.

Малын эмч нарын анхдугаар зөвлөгөөнийг 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан ба Мал эмнэлэгийн ерөнхий газар, МЭЭСБЛ, МЭЭШХ, Биокомбинат УТҮГ, Монголын нэгдсэн хувийн мал эмнэлгүүдийн дундын хоршоо, МоМЭХ, “Мон вет мед” эмийн компанийг урилгаар оролцуулж, мал эмнэлгийн салбарын чиглэлээр гарч байгаа хууль, дүрэм, заавар, зөвлөмж, мэдээллийг төрийн болон хувийн хэвшлийн эмч нарт өгсөн.

Монгол Улсын гавъяат малын их эмч Р.Содномдаржаа, Монгол Улсын зөвлөх малын эмч Ц.Сугир, Сүхбаатар аймгийн зөвлөх эмч Ж.Одсэр нар Сүхбаатар аймагт гарч байгаа

адуу, үхрийн халдваргүй өвчний талаар мэдээлэл хийж мал эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллахаар болоод байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийн талаар:

Монгол Улсын Засгийн Газраас БНХАУ-ын Засгийн Газрын хөнгөлөлттэй зээлийн тусламжаар Сүхбаатар аймагт “Махны үйлдвэр болон хорио цээрийн байгууламжийн цогцолбор” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус аймгийн Асгат суманд цогцолборыг байгуулахаар төлөвлөж, газар нутгийг шийдвэрлэх ажлын хэсэг Асгат сумын ИТХ, Засаг даргын тамгын газарт төслийг танилцуулж “Малын хорио цээрийн тусгаарлагдсан бүс”-ийг Асгат сумын 3-р багийн нутаг дэвсгэрт нийт 3114 га газарт байхаар тогтоож, холбогдох эрх зүйн баримт бичгийг баталгаажуулаад байна.

Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий уул уурхайн компаниудад орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг давуу эрхтэйгээр нийлүүлэх зорилгоор “Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхай” Зөвлөгөөний үеэр уул уурхайн компанид бүтээгдэхүүн нийлүүлж болох үйлдвэр эрхлэгчдийн төлөөллийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж үйлдвэр эрхлэгчдийг төлөөлж Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны Сүхбаатар аймаг дахь салбар холбооны тэргүүн компаниудтай хамтран ажиллах санал тавьж мэдээлэл хүргэж ажиллалаа.

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд 2019 онд Сүхбаатар аймагт нийт 1,0 тэрбум төгрөгийн эх үүсвэр батлагдсан. Тус эх үүсвэрийг аймаг орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого чиглэлтэй уялдуулах зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох тэргүүлэх чиглэлийг баталж Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.

Сүхбаатар аймагт сүүний үйлдвэрийг кластерын системээр хөгжүүлэх бодлогын хүрээнд “Сүхбаатар хөгжил ҮТП” төсөл боловсруулж төсөлд хөрөнгө оруулж хамтран хэрэгжүүлэх иргэн, аж ахуй нэгжийн төлөөллийн дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар, Засаг даргын зөвлөх Д.Амарбаясгалан, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Э. Өлзийтогтох, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтэн, ХХААХҮЯ-н сайдын зөвлөх н. Жадамба, АНУ-ын бяслаг үйлдвэрлэгч компанийн захирал Мак болон тус салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн төлөөллүүд оролцлоо.

Харилцаа холбооны талаар:

“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК Сүхбаатар аймгийн газар нь 2017-2019 онд “Үндсэн сүлжээний багтаамжийг аймгийн төвүүдэд 100Гбит/сек хүргэнэ” гэсэн зорилтын хүрээнд аймгийн төвд хүрч буй 1Гбит/сек багтаамжтай сүлжээг 100 дахин нэмэгдүүлэх тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг хийж байна. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр аймгийн төв-сумын төв гэсэн мэдээллийн өндөр хурдны замыг бий болгож, сүлжээний багтаамжийг эрс нэмэгдүүлснээр мэдээлэл, холбооны үйлчилгээ эрхлэгч компаниудын үзүүлж буй

үйлчилгээний чанар тухайн байршилд 5-20 дахин нэмэгдэхээс гадна дараа үеийн технологиуд нэвтрэх суурь нөхцөл хангагдах юм.

“Цахилгаан Холбоо” ХК Сүхбаатар аймаг дахь салбарт GPON /Интернэт болон Телефон/ сүлжээний холбоон дээрхи угсралтын ажлыг гүйцэтгэлээ.

Дөрөв. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2019 оны 03-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 854 иргэнээс эмэгтэй 415, бүртгэлтэй ажилгүй иргэн 665 иргэнээс , эмэгтэй 324 иргэн байна. 78 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 81 иргэнийг ажилд зуучилсан байна. Шинээр бий болсон 56 үүнээс эмэгтэй 33 иргэний ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төсөл зарлаж ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 53, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 12, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 36 иргэний төслийн материалыг хүлээн авч бүртгээд байна.

Онгон, Наран, Дарьганга, Эрдэнэцагаан сумдад 2 дугаар сарын 26-наас 3 дугаар сарын 12 хооронд ажиллаж 2019-2020 оны хөтөлбөрийн нээлтийг зохион байгуулан Багийн засаг дарга, бизнес эрхлэгчид, зорилтод бүлгийн хөдөлмөрийн насны иргэд, Баруун-Урт сумын 4, 5, 6 дугаар багийн хуралд 33 нийт 247 иргэнд мэдээлэл хийж тэдний асуусан асуултанд хариулж, 2019 оны сургалтын хэрэгцээний судалгаа авч 168 иргэнийг бүртгэсэн.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

03 дугаар сарын 06-ны өдөр Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 3 дугаар бүрэн дунд сургуультай хамтран “МЭРГЭЖЛЭЭ СОНГОСОН МИНИЙ ТУРШЛАГА” чөлөөт ярилцлагыг зохион байгууллаа. Тус сургуулийн 12 дугаар ангийн 18 сурагчийг 2017 онд МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар, Монгол-Хятад хэл судлал мэргэжлээр төгсөгч Б.Пагмаатай уулзуулж мэргэжлээ хэрхэн сонгосон болон сонгосон мэргэжлээрээ хэрхэн амжилттай суралцсан, ажилд ороход тулгарч байсан хүндрэлтэй асуудлууд, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг асуудлаар нээлттэй ярилцлага зохион байгуулсан. Мөн 03 дугаар сарын 13-ны өдрөөс 18-ны өдрийн хооронд “Олон улсын эмч нарын өдрийг угтан” Баруун-Урт сумын 3 дугаар БДС, аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ЕБС-ийн ахлах ангийн төгсөөд эмч мэргэжлээр суралцах сонирхолтой 31 сурагчийг эмнэлгийн үйл ажиллагаа, эмч нарын ажилтай танилцуулах аяллыг 4 хоногийн турш зохион байгууллаа. Танилцах аяллын төгсгөлд МУ-ын хүний гавьяат эмч Х.Батмөнх, аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдлага, эмч нарын төлөөлөл, ахмад сувилагч сурагчидтай уулзалт зохион байгуулж эмч мэргэжлийн онцлог, давуу талын талаар яриа хийж, сурагчдаас танилцах аяллын сэтгэгдлийг сонслоо.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийн ажлыг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс 15-ны хооронд зохион байгуулж 20 иргэний материалыг хүлээн авч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн ХАБЭА-н аймгийн зөвлөлийн хурлыг хуралдуулан 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан төсвийн хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.

Аймгийн МСҮТ-тэй хамтран Дөрвөлж ХХК-ны 97 ажилтан, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ны 20 ажилтанд ХАБЭА-н сургалтыг зохион байгуулж гэрчилгээ олголоо.

Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2019 онд нийгмийн халамжийн орон нутгийн төсвөөс 135,5 сая төгрөг, улсын төсвөөс 9377,9 сая төгрөг нийт 9513,4 сая төгрөгийг зарцуулагдахаар тусгагдсан байна. 03 дугаар сарын байдлаар Алдар цолтой ахмадын нэмэгдэлд 8,8 сая төгрөг, алдарт эхийн одонгийн нэмэгдэл 695,8 сая.төгрөг, насны хишигт 225,0 сая.төгрөг, өрх толгойлсон эхийн тэтгэмжид 40,6 сая.төгрөг, халамжийн тэтгэвэрт 635,4 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 201,5 сая.төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 114,4 сая.төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд 67,4 сая.төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт 111,6 сая.төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж 80,7 сая.төгрөг, цалинтай эхийн тэтгэмж 462,5 сая.төгрөг, хүнс тэжээл хөтөлбөрт 268,4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 17,8 сая төгрөгийн санхүүжилтийг авч арилжааны банкнуудаар дамжуулан олголт үүсгээд байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Баруун-Урт сумын зорилтот бүлгийн өрх толгойлсон 20-н эмэгтэйг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв. Арга хэмжээний үеэр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлага, мэргэжилтнүүд мэдээлэл хийж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнүүдэд хамрагдсан үсчид болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн гоо сайхны ангийн суралцагчид гоо сайхны үйлчилгээ үзүүллээ. Мөн арга хэмжээний үеэр "Жаахан шарга" ХЖТ-аас 2019 оны туршид өөрийн уран бүтээлийг үнэ төлбөргүй үзэх эрх 3 эмэгтэйд, Z Moda оёдлын цехээс 3 эмэгтэйд өөрсдийн урласан хавар намрын гадуур хувцас, 20 эмэгтэйд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдаас гарын бэлэг гардууллаа.

Биеийн тамир, спортын талаар:

Иргэдийг бүх нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд дараах тэмцээнүүдийг зохион байгуулаад байна.

Эм Эл цахиурт овоо ХХК-ний нэрэмжит Сүхбаатар аймгийн даамны холбооны нээлттэй тэмцээнд өсвөр үе насанд хүрэгчдийн 100 буудалт даамны тэмцээн зохион байгуулагдаж, 6 сумын 10 байгууллагын 100 гаруй тамирчид,

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан эмэгтэй волейболын тэмцээнд 27 багийн 190 гаруй тамирчид,

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Зодогтой бөхчүүд” II цэцэрлэгийн нэрэмжит хүүхдийн үндэсний бөхийн барилдаанд 11 цэцэрлэгийн 64 бөхчүүд,

Зэвсэгт хүчин байгуулагдсаны 98 жилийн ойн баярыг тохиолдуулан марш тактикийн тэмцээний хүрээнд зохион байгуулагдсан волейболын тэмцээнд 13 багийн 80 гаруй алба хаагч, үндэсний бөхийн барилдаанд 8 байгууллагын 32 алба хаагч, шатрын тэмцээнд 40 гаруй цэргийн албан хаагчид,

“Жаргалсайхан ирээдүй сан”-ийн нэрэмжит 2019 оны Залуучуудын аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд 4 сумын 16 байгууллагын 24 тамирчид,

МУ-ын харцага Дахын Одсүрэн агсны нэрэмжит үндэсний бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн Дарьганга суманд зохион байгуулагдаж 7 багийн 40 тамирчид,

2019 оны аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн волейболын тэмцээн 2 насны ангиллаар зохион байгуулагдаж Түмэнцогт, Мөнххаан, Эрдэнэцагаан, Халзан, Сүхбаатар сумд, Аймгийн 5 сургуулийн баг тамирчид нийт 32 багийн 260 гаруй тамирчид,

Чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнд эрэгтэй 14 жин эмэгтэй -6 жингийн ангилалд 12 багийн 140 гаруй тамирчид,

2019 оны аймгийн аварга шалгаруулах Аэробик гимнастикийн тэмцээн 3 насны ангиллаар зохион байгуулж 7 багийн 70 гаруй тамирчид тус тус оролцсон ба Даншигийн их аварга Ц.Буянтогтохын нэрэмжит 48 бөхийн барилдаан, волейболын өсвөр үеийн шигшээ баг, насанд хүрэгчдийн шигшээ багийн тамирчдын нөхөрсөг тоглолтыг зохион байгууллаа. Тоглолтод Монгол улсын спортын мастер Д.Болортуяа, Т.Оюунчимэг нар оролцсон.

Аймгийн шигшээ багийн тамирчид улс, бүсийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцлоо.

Пара жүдо улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2 мөнгө 4 хүрэл медаль,

Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах шатрын тэмцээнд шагналт байранд Э.Энх-од, С.Тамир II байр, Н.Наран-эрдэнэ V байр,

Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах анхан шатны тэмцээнд А.Эрхэмбаяр XI байр, Н.Сод-эрдэнэ VII байранд орж хагас шигшээ тэмцээнд оролцох эрхээ аваад байна.

Боловсрол, соёлын талаар:

Аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатарын урилгаар Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Масато Такаока болон бусад албаны хүмүүс тус аймагт айлчиллаа. Айлчлалын үеэр аймаг, орон нутгийн өнөөгийн байдал болон цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар ярилцслаа. Мөн ахлах ангийн сурагчдад Япон улсад суралцах боломж, сургалтын тэтгэлэгүүдийн талаар мэдээлэл өгч, нээлттэй ярилцлаа.

Монголын багш нарын 7-р их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох БСШУС-ын сайдын ирүүлсэн зааврын дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/142 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 40 нэр дэвшигчдээс 16 багш, ажилчдыг төлөөлөгчөөр сонгож баталгаажууллаа.

Зөвлөн туслах баг Онгон, Наран, Дарьганга, Эрдэнэцагаан сумын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж, хугацаатай үүрэг, даалгавар өгч ажиллалаа. Тус ажлын хүрээнд 280 эцэг эх, 260 сурагч, 56 багш нартай уулзан, мэдээлэл өгч, санал асуулга авлаа.

БСШУСЯ, Боловсролын үнэлгээний төвөөс орон даяар зохион байгуулсан Боловсролын чанарын судалгаа, үнэлгээний шалгалтын ажлын хэсэг 16 сургуульд ажиллаж, 3 дугаар ангийн 507 сурагч, 9 дүгээр ангийн 878 сурагч, 10 дугаар ангийн 376 сурагч, эцэг эх 25, удирдах ажилтнууд 16 шалгатанд хамрагдлаа.

6-7 дугаар ангийн Монгол хэлний массын олимпиадыг зохион байгуулж 6 дугаар ангийн 986 сурагч, 7 дугаар ангийн 881 сурагч оролцлоо. Мөн Монгол хэлний багш нарын онлайн олимпиадыг зохион байгуулж 50 багш оролцлоо.

2018 оны ажлын үр дүн хангалтгүй дүгнэгдсэн Мөнххаан сумын ЕБС-ийн захирлыг албан тушаал бууруулж, Эрдэнэцагаан сумын 1-р цэцэрлэгийн эрхлэгчийг ажлаас нь чөлөөлж хариуцлага тооцож ажиллалаа.

Гэр бүл, хүүхэд залуучууд талаар:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/89 дүгээр захирамжаар хурдан морины унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01 хүртэл өвөл, хаврын уралдаан, үсэргээ, сунгаа харьяа нутаг дэвсгэрт зохион байгуулахыг хориглосон шийдвэрийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн аймгийн морин спорт уяачдын холбоо болон 13 сумын уяачдын холбоонд хүүхэд хамгааллын тухай хууль, дүрмийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс баталсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй ажлын нэг болох аймгийн хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай сургалтын төлөвлөгөөний дагуу хамтарсан багийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 13 сумын хамтарсан багийн 85 гишүүд, 60 цэцэрлэгийн багш хамрагдлаа. Мөн аймгийн Засаг даргын 2019 оны А/143 дугаар захирамжаар албан байгууллага, аж ахуйн нэгж бүрт Гэр бүлийн зөвлөл байгуулан, гэр бүлийн зөвлөгч ажиллуулахаар шийдвэрлэсэн ба гэр бүлийн 60 зөвлөгч нарыг 2 өдрийн сургалтаар бэлтгэлээ.

Аймгийн хүүхдийн хууль зүйн хороог 1 удаа хуралдаж хүүхдийн кейс дээр ажиллаж хамтарсан багаар хэрхэн үйлчилгээ хүргэх талаар холбогдох хамтарсан багт зөвлөгөө, зөвлөмж өглөө.

Эрүүл мэндийн талаар:

"ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЭРҮҮЛ ИРГЭН" уриан дор аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж Эрүүл Мэндийн Газрын дарга, Сумдын Засаг Дарга, Эрүүл Мэндийн Төвийн дарга нарын хамтран ажиллах гуравласан гэрээ байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлаар 2 шүдний эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгалаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар АНЭ-ийн КТГ-ын аппаратын засварын хөрөнгийг гаргах эх үүсвэрийг шийдвэрлүүлж, Уламжлалт анагаах ухааны төвийн үйл ажиллагааг эхлүүлэх саналыг бэлтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 5 дугаар сараас эхлүүлэхээр боллоо.

“Өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжье” өдөрлөгийг зохион байгуулж 10-12 р ангийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.

“Эмнэлгийн эрх зүй ба ёс зүй” сэдэвт 2 багц сургалтыг зохион байгуулж 100 ЭМСалбарын удирдах ажилтан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх төсөлд Дарьганга сумын ЭМТ хамрагдаж 5 төрлийн аппарат хэрэгсэл, 1000 ширхэг оношлуураар хангагдаж, төсөл хэрэгжүүлэх багийн сургалтад 4 эмч, бага эмч нар хамрагдаж байна.

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин, халдварт саагийн эсрэг идэвхигүйжүүлсэн вакцинуудыг дархлаажуулалтад нэвтрүүлэх сургалтыг АНЭ-ийн нярайн эмч, хүүхдийн тасгийн эрхлэгч, сум, өрхийн ЭМТ-ийн эрхлэгч, их эмч, ахлах сувилагч, вакцинолог бага эмч нарт зохион байгууллаа.

Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, хяналтыг сайжруулах, тархалт болон хүндрэлээс сэргийлэх зорилгоор “Сүрьеэ өвчнийг эрт илрүүлж, бүрэн эдгэрүүлэхэд сум, өрхийн эмч, мэргэжилтнүүдийн оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 2 сарын аяныг эхлүүлээд байна.

“Олон улсын хэрэглэгчдийн эрхийг хамгаалах өдөр”-өөр ЭМСалбарын 2019 онд баримтлах бодлого, зорилго, зорилтоо танилцуулж, иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл хүргэж иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллалаа. Үүнд эмчид талархсан сэтгэгдлээ 10 хүн, сэтгэл ханамжийн судалгаанд 56 хүн, ясны сийрэгжилт -12 хүн, цусан дахь сахар -20 хүнд тодорхойлж, артерийн даралт -8 хүн, хавдрын эрт илрүүл гийн асуумж судалгаанд 15 хүн хамрагдаж 20 төрлийн 350 ширхэг брошур, гарын авлагаар хангасан байна.

ТАВ: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын аймаг дахь орон тооны бус зөвлөлийн 2019 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. III/14-ний өдөр “Хүүхэд хэрэглэгч”, “Ухаалаг аюулгүй бараа бүтээгдэхүүн”, “Хуурамч мөнгийг хэрхэн таних” зэрэг сэдвүүдээр аймгийн төв буюу Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн хоолны газар, хүнсний дэлгүүрийн 95 дарга, захирлуудад сургалт зохион байгуулж, 150 гаруй гарын авлага тараалаа. Мөн III/15-нд “Ухаалаг аюулгүй бараа бүтээгдэхүүн” нээлттэй хаалганы өдөрлөгийг Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт, хэмжилзүйн хэлтэс, Хөдөлмөр, нийгмийн

халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Монгол банкны салбар болон бусад банкуудтай хамтран зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр нийт 147 иргэн хамрагдаж төрийн үйлчилгээг хүртэн 18 төрлийн 314 ш гарын авлагыг тараан 21 иргэний кальцийг тодорхойлж, 45 иргэний сахарын хэмжээг хэмжин байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллалаа.

Аймгийн Засаг даргын дэргэд Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр аймгийн хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Тус зөвлөгөөний зорилго нь улсын хил хамгаалалтад сайн дурын үндсэн дээр оролцох иргэдийг ажил үйлдвэрлэл явуулж буй байрлалаар нь байнгын болон түр хугацаагаар хил хамгаалалтад туслах хүч болгон зохион байгуулах, Монгол улсын иргэн Хилийн тухай хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах юм. Зөвлөгөөний үеэр Удирдлагууд болон зөвлөлийн гишүүд цаашид тулгамдаж буй асуудал болон хийж хэрэгжүүлэх ажлаа нээлттэй ярилцлаа. Аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар цаашид хил хамгаалах байгууллага болон хил дээр ажиллаж буй мэргэжлийн байгууллагууд улсын хилээр хууль бусаар гарч буй хүнсний бүтээгдэхүүн, мансууруулах бодис, мах махан бүтээгдэхүүн, арьс шир зэрэг хилээр гаргахыг хориглосон эд зүйлсийг хууль бусаар гаргах явдал байсаар байгаад дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох тал дээр онцгой анхаарч, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахыг анхаарууллаа.

Аймгийн Цагдаагийн газарт Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын гадна орчны телехяналтын камерыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох ажлын дэд бүтцийг шийдвэрлэхэд зориулан 4,025,000 / Дөрвөн сая хорин таван мянга/ төгрөг, Цагдаагийн газрын конторын барилгын өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөл, төсөвт өртгийн тооцоог мэргэжлийн байгууллагаар боловсруулахад зориулж 25 000 000 /Хорин таван сая/ төгрөгийн дэмжлэгийг тус тус шийдвэрлэлээ.

"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" сэдэвт сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 20-21 өдрүүдэд Цагдаагийн Ерөнхий газар, Олон улсын хөгжлийн эрх зүйн /IDLO/ байгууллага хамтран Сүхбаатар аймагт зохион байгууллаа. Сургалтад Цагдаагийн газар, Шүүх, Прокурор, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажилтан алба хаагч нар хамрагдаж гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэх мэдлэгээ бататгалаа.

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар, Баруун-Урт сумын Засаг даргын Тамгийн газартай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн ойр орчныг телехяналтын камерын нэгдсэн системд холбох, иргэдийн өөрийн өмч хөрөнгөө хамгаалахад цагдаагийн газар хамтран ажиллах, хяналт тавих, гарч болох бусад эрсдэлээс хамгаалахын тулд аж ахуй нэгжүүдийн дарга эрхлэгч нартай хамтарсан хэлэлцүүлэг зохион байгууллаа.

2019 оны 03 дугаар сарын 12-ны өдөр "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг тохиолдуулан Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, "Жаахан шарга" театрын хамтарсан "МӨРДӨС ДУУЛСАН АЯЛГУУ-4" тоглолтыг зохион байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэмжлэгтэйгээр Шүүхийн шинжилгээний албанаас санаачлан зохион байгуулсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хууль хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоо, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа.

ЗУРГАА.СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭ

Сүхбаатар сумын сарын ажлын товч мэдээ:

"Саруул ухаанд сайхан ирээдүй цогцлооно, Холч бодолд хүмүүний хөгжлийг бүтээнэ" уриан дор сумын эрэгтэйчүүдийн анхдугаар чуулга уулзалтыг зохион байгууллаа. Чуулга уулзалтанд баг тус бүрээс 50-н эрэгтэй, нийт 200 эрэгтэй хамрагдсан. Чуулга уулзалтад:

-Монгол эр хүний тухай ёс заншил, хүндлэлийн талаар аймгийн Эрдэнэмандал хийдийн унзад лам Энхбат

-“Хорт зуршлаас сэргийлье” сэдвээр аймгийн архидалт амжилтгүй нийгэмлэг “АА”

-Зөв бодол, зөв үйлдэл, гэрэлт ирээдүй сэдэвт хандлагын сургалт

-Монгол эр хүний холч ухаан, ахуй амьдралд, монгол морины шинж, уяа сойлго сэдвийн дор Монгол улсын тод манлай уяач Д.Одгэрэл тус тус яриа таниулга хийсэн. Мөн цаашид хэрхэн яаж сум, орон нутгаа хөгжүүлэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулж “Сумын хөгжилд иргэн бүр оролцоцгооё” уриалгыг гаргалаа.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 03-р сарын 21-нд зохион явууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв хамтран Монгол Улсад шинэ зэвсэгт хүч үүсэн байгуулагдсаны 98 жилийн ой, Монгол цэргийн өдрөөр "Эрчүүдээ хайрлая " уриан доор "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгуулж, 120 эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулан, сумын бодлого, чиглэл, цаашид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар танилцууллаа.

03-р сарын 13-нд ЗДТГ-ын ХАЗМэргэжилтэн, 2-р багийн Засаг дарга хамтран “Хурдан морины уралдаанд хориг тавих тухай” сумын Засаг даргын 2019 оны А/17 дугаар захирамжийн дагуу сумын төвд хурдан морь тэжээж буй 10-н уяачид Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/89 дугаар захирамжийг танилцуулан хурдан морины уралдаанч хүүхдийн хамгаалалд үүрэг хүлээгчдийн гарын авлагыг тарааж яриа таниулга хийсэн.

Баяндэлгэр сумын сарын ажлын товч мэдээ:

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар 2019 онд хийх ажлын төлөвлөгөө, ГХУС зөвлөлийн 2019 оны ажлын төлөвлөгөөг баталж сумын ИТХ-ын дарга сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээг байгууллаа. Мөн ИТХ-ын нарийн бичгийн дарга ИТХ-ын ажилтан, багийн ИНХ-ын дарга нартай хөдөлмөрийн гэрээ байгууллаа.

Монгол улсын засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх таниулах өдөр”-ийн хүрээнд сумын нийт төсөвт байгууллагууд болон аж ахуй нэгжүүдийг хамрагдлаа. Сургалт, дадлагын үед 73 ажилтан албан хаагч иргэд 667 хүүхэд, 32 тээврийн хэрэгсэл, сумын мэргэжлийн ангийн 66 албан хаагчид хамрагдсан байна. Мөн сургалт дадлагын үеэр сургууль цэцэрлэгийн хүүхдүүдэд газар хөдлөлтийн талаарх сургалтыг хийж материал тарааж ажиллав.

Орон нутгийн өмчийн газарт үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний материалыг тулган баталгаажуулж сумын нэгдсэн тайланг хүргүүлээд байна.

Төсөвт байгууллагын 2018 оны жилийн эцсийн тайланд аудит хийж дууссан ба дүгнэлтийг гаргуулахаар хүлээж байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилт төсвийн хуваарийн дагуу санхүүжилт хийгдэж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

“Хүүхэд хэрэглэгч” арга хэмжээг ЗДТГ, АУБ нартай хамтран 03-р сарын 15-ны өдөр зохион байгуулж, 1-5 ангийн 510, 6-11 ангийн 45 сурагчидад төлөвлөгөөний дагуу нээлттэй хичээл, сургалт, ханын самбар хийх, мэдээлэл солилцох чиглэлээр оролцож мэдлэг чадварын дадал эзэмшүүллээ.

“Эрүүл монгол- Эмэгтэй” өдөрлөгийг 03-р сарын 03-ны өдөр зохион байгуулж, 158 охид, бүсгүйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүлжүүлэх, зөвлөгөө зөвлөмжийг өглөө.

Мөн “Эрчүүдээ хайрлая” нээлттэй өдөрлөгийг 03-р сарын 15-ны өдөр эрчүүдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, зөвлөгөө зөвлөмж өгөх, эрүүлжүүлэх зорилгоор зохион байгууллаа. Тус өдөрлөгт 74 эрэгтэй үзлэг, шинжилгээнд хамрагдлаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт зориулан “Шууданч тагтаа” арга хэмжээг зохион байгуулж 200 гаруй захидлыг эздэд нь хүргүүлэх үйлчилгээг ангийн дарга нарын холбоотой хамтран зохион байгууллаа.

Албан байгууллага аж ахуй нэгжүүдэд хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж 92 иргэнд гарын авлага материалаар хангаллаа.

Дэлхийн усны өдрөөр ЕБС-ийн 2-р ангийн 98 сурагчид Ус бидний амьдралд видео бичлэгээр хичээл орлоо. Сургуулийн өмнөх боловсролын багш ажилчид, эцэг, эхчүүдийн дунд АХА тэмцээнийг зохион байгуулж, “Усны нөөц” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Уулбаян сумын сарын ажлын товч мэдээ:

Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн нэгдсэн зөвлөгөөн”-ийг 3 сарын 13-нд зохион байгууллаа.

Орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 5194.6 мянган төгрөг орохоос 9498.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 182.8 хувийн биелэлттэй байна.

БСУГ-аас сургуулийн ажлыг дүгнэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг 21 багш, 10 ажилтан, 36 суралцагч, 125 эцэг эхээс авсан байна.

Олон нийтийн мэдээллийн цагаар Ерөнхий боловсролын сургууль 2018-2019 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар иргэдэд мэдээлэл өглөө.

Мөн “Хүүхэд-гэр бүлийн баялаг” эцэг эхийн зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулж, 128 эцэг, эх асран хамгаалагчдад номын санч, багш нар тус тусын чиглэлээр мэдээлэл хийж, санал бодлоо солилцлоо.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” төслийн хүрээнд БТА ахмад багш Л.Цэвэгжав дунд ангийн сурагчдын Монгол бичгийн мэдлэгийг сайжруулах, хоцрогдлыг арилгах зорилгоор сурагчдад сургалт явуулж байгаа ба сурагчдын мэдлэгийн ахицын тайлантай танилцлаа.

Цэцэрлэгийн багш, албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ахмад багш Л.Цэвэгжавтай хамтран 3-н “Монгол бичиг”-ийн сургалтыг 7 хоногт 3 удаа тогтмол зохион байгуулж байна.

Сумын 5 багийн бүсгүйчүүдийн дунд “Бүсгүйчүүд дуулж байна” анхдугаар уралдааныг зохион байгуулж 31 хүн оролцож, 280 гаруй үзэгч сонирхлоо.

Аймгийн ГХУССЗөвлөл, Замын Цагдаагийн тасагтай хамтран “Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрэм”, жолоодлогын тэмцээнийг зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Дуулах өв” уралдааны 1-р шатыг ажилтай зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2019-2020 онд хэрэгжих хөтөлбөрүүдийн мэдээллийг цахимаар болон цаасан хэлбэрээр хэвлэж, иргэдийн мэдээллийн цагаар 83 иргэнд танилцуулсан. Энэхүү мэдээллийн дагуу нийтийг хамарсан-3, ажлын байрыг дэмжих-1, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний-1 төслийг хүлээн авч, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт уламжлаад байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч буй өрхийн хөдөлмөрийн насны иргэдээс 6 иргэнийг ямаа самнах ажилд холбон зуучлан, түр ажлын байраар хангаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн системд ажил хайгч 2 иргэнийг бүртгэн, шинэ ажлын байранд 2, ажлын байранд зууч лалаар 2 иргэний мэдээллийг бүртгэн баталгаажууллаа.

03-р сарын 11-нд хамтарсан багийн гишүүд, цэцэрлэгийн албан хаагчдад Хүүхэд хамгаалал, Хамтарсан багийн чиг үүргийн талаар мэдээлэл өглөө. Сургалтаар багш ажилчид, хамтарсан багийн гишүүдтэй хамтран ажиллах, ажиллах явцдаа хүүхдээ хамгаалах арга зүйд суралцлаа.

Олон нийтийн мэдээллийн цагаар 11 сарын 01-ээс 05 сарын 01 хүртэл хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосон Засгийн газрын тогтоол, аймаг, сумын Засаг даргын захирамжийг 50 иргэнд танилцууллаа.

108 гомдлын дагуу 1 кейсийн хувийн хэргийн бүрдүүлэлт хийж, аймгийн хууль зүйн хороонд шилжүүлээд байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 82908.4 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Сайн дурын даатгалд 124 иргэнтэй шинээр гэрээ байгуулан 11918.2 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 134 даатгуулагчийг даатгаж 4914.8 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээд байна.

Нийт 399 хүн эмнэлгийн үзлэгт хамруулсны дотор амбулаторид 249 урьдчилан сэргийлэх үзлэгээр 121 хүн, идэвхтэй диспансерийн хяналтад 6, гэрийн идэвхтэй хяналтад 24, гэрийн дуудлагаар 20 хүн үзэж, 17 хүн хэвтүүлэн эмчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлээ.

Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдэд Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт хийж, гарын авлага тараалаа.

Аж ахуй нэгж байгууллага бүр орчноо цэвэрлэж, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг 3 иргэнээр цэвэрлүүлж 60.000 төгрөгийн урамшуулал олгосон. Мөн хөдөөгийн багийн Иргэдийн нийтийн хурлаар өвөлжөө, хаваржаагаа цэвэрлэх, ариутгах, усны савны хэрэглээ, ус ашиглалт, ахуйн болон хээрийн түймрийн талаар мэдээлэл өгч гарын авлага тараах материалыг 200 өрхөд өгч ажиллалаа.

“Нэг удаагийн нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео уралдаан, “Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт гар зургийн уралдаануудыг зохион байгуулаад байна.

Эрдэнэцагаан сумын сарын ажлын товч мэдээ:

3-р сарын 1-н буюу Эх орончдын баярыг тохиолдуулан “Малчдын зөвлөөн”- ийг ИТХ, ЗДТГ, Соёлын төв хамтран зохион байгуулж 8-н багийн 300 гаруй малчид оролцлоо. Тус зөвлөгөөний үеэр сумын ЗДТГ, Соёлын төвийн албан хаагчдын “Энх мэндийн хадаг” урлагийн тоглолтыг зохион байгуулсан ба 14 зүйлээр уриалга гаргалаа.

3-р багийн Авдрантын хөндий гэдэг газар 3-р сарын 4-нд хонины өвчний дуудлага хүлээн авсан ба дээж авч түргэвчилсэн тестээр үзэхэд хонины А0 өвчин байж болзошгүй гэсэн урьдчилсан дүнгээр тогтоон, дээжийг Улсын төв лабораторируу явуулж 3-р сарын 07-ны өдөр шүлхий өвчин мөн болох нь тогтоогдсон. Иймд нэн даруй зохих арга хэмжээг авч ажиллан 10 хэсэг гарган 7 хоногийн хугацаанд хонь, ямаа, үхэрт ээлжит вакцинжуулалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэлээ.

Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хичээллүүлэх зорилгоор дэлхийн усны өдрийг тохиолдуулан Буйр нуур, мэнэнгийн талын сав газрын захиргаатай хамтран сумын ард иргэдийн дунд Гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан ба 6 аж ахуй нэгж, албан байгууллагын 57 албан хаагчид тэмцээнд хамрагдлаа. Мөн ЕБС-н ахлах ангийн сурагч нарт сургалт, сурталчилгаа хийж, ТАТА ТУНГА асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулан 43 сурагчийг хамрууллаа.

ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн Үзэмчин хошууны Монгол Үндэсний хүүхдийн цэцэрлэгт 5 багш, 5 ажилтаныг туршлага солилцуулж хамтарсан үйл ажиллагаа зохион байгууллаа.

Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Багшийн хөгжлийн тухай хуулиар цэцэрлэгийн багш, ажилчдад сургалт хийлээ.

МУЗГ-ын “Нэг удаагийн нийлэг хальсан уут хэрэглэхийг хориглох тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор цэцэрлэгийн багш, ажилчид өөрчдийн хүчээр даавуун улавч оёж хэрэглэж байна.

Сумын соёлын төвөөс Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан арга хэмжээг баярын хурал, хүндэтгэлийн концерт, ЕБС-ийн сурагчдын дунд Миний ээж хөөрхөн дууны тэмцээн, Монголын сайхан ээжүүд захидлын уралдаан, Миний ээж хөөрхөн зургийн уралдааныг амжилттай зохион явуулсан. Уг тэмцээнүүдэд 60 гаруй сурагчид оролцлоо.

Халзан сумын сарын ажлын товч мэдээ:

2019 оны 03 дүгээр сарын 19-20 өдрүүдэд Засаг дарга хөдөөгийн гурван багийн 50 өрхийн иргэдтэй уулзаж хаваржилт төл божилтын байдалтай танилцлаа.

2019 оны 03-р сарын 25 ны өдөр "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 2018 оны үйл ажиллагааны тайлан, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар танилцуулга мэдээлэл хийлээ. Мөн аймгийн ХШҮДАХ-ийн ахлах мэргэжилтэн М.Оюунтөгс "Төрийн албан хаагчийн манлайлал, ур чадвар" лекц уншлаа.

2019 оны 03 дугаар сарын 22 ны өдөр Гамшгийн үеийн бэлэн байдлыг шалгах үзлэг шалгалтад мэргэжлийн ангийн 66 бие бүрэлдэхүүн жагсаж бэлэн байдлаа шалгууллаа. Мөн газар хөдлөлтийн үеийн анхны тусламж үзүүлэх сургалтыг 1-9-р ангийн сурагчдад хийлээ.

“Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа”, ХАБЭАхуйн тухай хуулийн сургалтийг 15 иргэн, албан газрын дарга, эрхлэгч, ХАБЭА хариуцсан 20 ажилтан, албан газрын үйлчилгээний 30 ажилтнуудад зохион байгууллаа. Мөн ЕБСургуулийн дотуур байрны хүүхдүүдийн хүсэлтээр “Хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжил, оролцоо” сургалтыг 20 хүүхдэд хийсэн бол ЗДТГазрын байгал орчны мэргэжилтэнтэй хамтран “Галын аюул, хээрийн түймэр, хог хаягдал” сургалтыг 15 иргэнд зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуульд зохион байгуулагдсан мэргэжил сурталчлах өдөрлөгийн хүрээнд “Орос хэлний хичээлийн 14 хоногийн аянг зарлаж багш сурагчдын дунд “АХА” тэмцээн, сурагчдын дунд орос дуу, шүлгийн уралдаан, 6-9-р ангийн сурагчдын дунд мини олимпиадыг тус тус зохион явууллаа. Мөн багш нар боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд “Хүүхдэд ээлтэй гэр”, “Хөгжсөн багш- Хөгжлийн хөтөч” нэртэй 2 төслийг бичиж БСУГ-т хүргүүлээд байна.

МУЗГ-ын “Нэг удаагийн нийлэг хальсан уут хэрэглэхийг хориглох тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор цэцэрлэгийн багш, ажилчид өөрчдийн хүчээр даавуун улавч оёж хэрэглэж байна.

Хөдөлмөрийн мэдээллийн санд ажил хайгч 5 иргэн бүртгэлээ. Ажил зуучлалаар 3 иргэн түр ажлын байранд зуучиллаа. Шинэ ажлын байр 5 гарсан байна. Хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих сангийн шугамаар хэрэгжих хөтөлбөрт хамрагдах 4 иргэний өрхийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх төслийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлээд байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр зорилтот өрхийн “Үзэсгэлэн худалдаа”-г зохин байгуулж, 20 иргэн хамрагдлаа. Мөн “Бүсгүйчүүддээ баярлалаа” уулзалт, ярилцлага зохион байгуулсан ба “Эрдэнэ ЗММ” хүнсний дэлгүүр зорилтот бүлгийн 17 иргэнийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж төсөвт байгууллагууд болон аж ахуй нэгжүүд хуваарт газраа цэвэрлэлээ.

2-р сарын 19-өөс 3-р сарын 15-ны хооронд Шүлхий өвчинөөс сэргийлэх тарилгыг 5 ажлын хэсэг хийж гүйцэтгэлээ. Тарилгад 10588 мал хамрагдаж, 21,7 л вакцин зарцууллаа.

Баруун-Урт сумын сарын ажлын товч мэдээ:

Тамгын газрын дотоод зөвлөгөөнийг зохион байгуулж, тасаг нэгжийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн, сумын Засаг даргын 01 тоот албан даалгавар гарган, хяналтад авч ажиллаж байна.

Орон нутгийн BBS телевизийн “Хөгжлийн тухай ярилцъя” нэвтрүүлэгт сумын Засаг дарга оролцон 2018 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын талаар иргэдэд мэдээлэл өглөө.

Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх ажлын хүрээнд 609 айл өрхөөр орж санал хүсэлтийг нь сонсож ажиллалаа. Мөн орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал, асуулгыг 847 өрхөөс аваад байна.

Баруун-Урт сумын төвөөс мал гаргах хэлэлцүүлэг зохион байгуулж, “Мал бэлчээхийг хориглох, бүсийг тогтоох тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг батлуулаад байна.

24 байгууллага, аж ахуйн нэгжид шаардлага тавьж, орчныг нь цэвэрлүүллээ. Мөн 1-р багийн “Мандал” хорооллын иргэдийг уриалан хэсэгчилсэн цэвэрлэгээ хийж, 80 иргэн 2 машин хог, 4-р багийн ажлын алба Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазартай хамтран Өнөр хороололын 3-р байр, 38 айлын орон сууцны иргэдийг хамруулж байрны гадна тайлбайд нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж 2 машин хог, 7-р багийн нутаг дэвсгэрт байрлах 36б байрны иргэдийг хамруулж, цэвэрлэгээ хийлгэн хоггүй орчин бүрдүүлэн ажиллаж байна.

МУЗГ-ын “Нэг удаагийн нийлэг хальсан уут хэрэглэхийг хориглох тухай” 189-р тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “1 хүүхэд-1 даавуун уут” аяныг зохион байгуулж, 4 ЕБСургууль, 11 СӨБ-ын байгууллагын багш, ажилчид сурагчдын дунд уриалга гарган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 01 албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор 50 иргэнд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг хүргээд байна.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан иргэдэд “Цэнгэг ус-Тэгш хүртээмж” сэдвийн хүрээнд олон нийтийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл, сурталчилгаа хийж

ажиллалаа. Мөн “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай хамтран Баруун-Урт голын эхийг цэвэрлэж, сумын төвийг тойрсон малын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулан 65 малын сэг зэм устгаж, тус тус 2 машин хогийг нэгдсэн хогийн цэгт булж устгалаа.

Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр “Сүхбаатар ойжуулалт” сум дундын ойн анги ОНӨҮГ-н үйл ажиллагаанд 25,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Сүхбаатар сумын ЗДТГ, ГХБХБГ-тай хамтран Баруун-Урт сумын хилийн цэсийг тодруулах, Баруун-Урт сумын төвийн ойр орчимд зөвшөөрөлгүй буусан хашаа, малын зүчээг буулгах, нүүлгэх ажлын хэсгийг байгуулаад байна.

3-р сарын 10-ны өдрөөс эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээ авагч иргэдийн олголтыг тулгаж, илүү орсон 32 иргэний 1, 2-р сарын санхүүжилтийг буцаан татаж, дутуу татагдсан иргэдийн мэдээллийг жагсаалтаар хүргүүлэн, нөхөн олгох ажлыг хийхээс гадна, “Цалинтай ээж” хөтөлбөрийн 1001 эхийн хувийн хэргийг программд хүн тус бүрээр нь тулгалтыг хийж, Нийгмийн даатгал төлөгдсөн болон ажилд орсон 16 эхчүүдийн үйлчилгээг зогсоон илүү, дутуу олголтгүй ажиллаж байна.

Засгийн газраас тогтоосон жишиг үнийн дагуу ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараах хөнгөлөлт тусламжийг үзүүллээ. Үүнд:

№	Хөнгөлөлт, тусламжийн төрөл		Хүний тоо	Санхүүжилт
1	Шүд	Ахмад настан	12	1340000
		ХБИргэн		
2	Сувилал	Ахмад настан	5	1213000
3	Тэргэнцэр / захиалгаар/	Ахмад	1	150000
4	Нурууны бүс, өвдгөвч /Захиалгаар/	Ахмад	1	180000
5	Даралтын аппарат, ярьдаг цаг, цагаан таяг	Ахмад	1	235000
6	Хөтөвч, суултуур	Ахмад	1	80000
7	Хиймэл өвдөгний үе	Ахмад	1	5000000
8	Сонсголын аппарат	Ахмад	1	350000
9	Хиймэл уян болор	ХБИргэн	1	460000
10	Дизи тоглуулагч	ХБИргэн	1	520000
11	Хавар, намрын гутал	ХБИргэн	1	120000
Нийт			26	9648000

ХЭБ-ийн үйлчилгээ авч байгаа 2,4,6-р багийн нийт 172 өрхөд бичилт хийн иргэний үнэмлэхний хугацаа дууссан 1 болон төрсний гэрчилгээний лавлагааны 3 хуулбарыг аван хувийн хэргийн баяжилтыг цаг тухай бүрт хийж байна.

“Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан сумын ИТХ-ын төлөөлөгчид, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаас санаачлан 65 зорилтот бүлгийн болон өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэйчүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, тусламж, дэмжлэг үзүүллээ.

Баруун-Урт сумын ЗДТГ, "Хатан" сан ТББ-аас хамтран олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Эмэгтэйчүүдээ дэмжье - Эмэгтэйчүүдээ сонсьё" аяныг зохион байгуулсан ба эмэгтэйчүүдийг дэмжигч байгууллагаар:Тэргүүн байрыг

2дугаарцэцэрлэг, дэд байрыг ОБГазар, гутгаар байрыг Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль тус тус шалгарсан байна.

Хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан нөөцийн өвс тараах ажлыг зохион байгуулж байна. Эхний ээлжинд 20 малчин өрхөд өвс өгөөд байна.

Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан АНЭ-ээс сумын ЗДТГ-тай хамтран "Хишиг өдөр" арга хэмжээг 03 дугаар сарын 25-нд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд тус байгууллагуудын албан хаагчид нэг өдрийн хугацаанд харилцан ажлын байраа солилцож мэргэжлийн онцлог үйл ажиллагааны туршлага хуваалцан ажилласан. Энэ нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдаа, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх ач холбогдолтой юм.

Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн 3 аж ахуйн нэгж, тамхи худалдан борлуулах зөвшөөрөл хүссэн 3 аж ахуйн нэгжийн холбогдох материалыг хүлээн авч зөвшөөрөл олгосон.

Хяналтын камерын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт 68 аж ахуйн нэгж оролцож санал бодлоо солилцсон.

Сумын хэмжээнд үлийн цагаан оготонотой энгийн механик, биологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулах, оготны тархалт, идэвхижилтийг бууруулж, малын бэлчээрийг хамгаалах зорилгоор 3-р сарын 05-наас эхлэн ажлын хэсэг 8 дугаар багийн нутаг дэвсгэр болох Төмөртэй, Шанд, Голын эх, Энх-Амар, Хөөвөр, Чандмань, Эрдэнэ ус, Үет, Мандал, Хажуу булаг, Говь зэрэг газруудад ажиллан, оготны тархалттай газруудыг үзэж, фото зургаар баримтжуулж ажиллаж байна.

ЕБС-ийн үдийн цай, Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэгдэх хүнсний бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нээлттэй тендерийн сургалтад 20 аж ахуйн нэгж хамрагдлаа.

Гамшиг, ослын үед нүүлгэн шилжүүлэх сургалтад баг бүрийн төлөөлөл иргэдийн хамруулж гамшгаас хамгаалах мэдлэг олгосон.

Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг сайжруулах ажлын хүрээнд "Хүлээж биш хүрч үйлчилье" үйл ажиллагааг зохион байгуулж, зүүн бүсийн худалдааны төвд төрийн өмгөөлөгч н.Дэлгэрцэцэгтэй хамтран иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүллээ. Мөн 1-р багийн ажлын алба НХҮГ, ОБГ, ЦГ, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазруудтай хамтран "Иргэн таны хуулийн мэдлэгт" хэлэлцүүлгийг зохион байгуулж, 12 иргэний санал хүсэлтийг сонслоо.

7-р багийн нутаг дэвсгэрт байрлах 8-н айлуудын орон сууцны оршин суугчидтай сумын Засаг дарга М.Идэрбат уулзаж, санал бодлыг нь сонсож, тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлаа. Мөн 3-р сарын 22-ны өдөр багийн иргэдийн нийгмийн идэвхийг сайжруулах, тэдэнд төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын санал, асуулга авах өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгт төрийн 10 байгууллагыг урьж оролцуулан иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос хүргэж ажиллалаа.

9-р багийн ажлын албанаас санаачлан Насан туршийн боловсрол төв, ИНХ-ын ажлын албатай хамтран "Иргэн таньд" сургалтыг зохион байгуулж, гэр бүлийн харилцаа, өрхийн санхүүгээ хэрхэн зохицуулах вэ?, сум хөгжүүлэх сангийн зээл, "Хайлаастын залуус" клубын

мэдээ мэдээллийг өгч, иргэдийг цаашдын үйл ажиллагаанд идэвхитэй хамрагдахыг уриаллаа.

Багийн ажлын алба Цахирмаа эмэгтэйчүүдийн клубтэй хамтран 100 эмэгтэйн уулзалт, хэлэлцүүлгийг хийсэн. Уулзалтаар эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, гоо сайхан, харилцаа хандлагын талаар яриа таниулга хийж, гарын бэлэг гардууллаа.

Асгат сумын сарын ажлын товч мэдээ:

ИТХ-ын санаачлагаар дэлхийн усны өдрийг тохиолдуулан 3-р сарын 22-нд “Ус чандмань эрдэнэ” сэдэвт хэлэлцүүлгийг ундны ус түгээгч, худаг ажиллуулдаг иргэд болон холбогдох хүмүүс албан байгууллагын дарга эрхлэгч нарын дунд зохион байгууллаа.

Төрийн албан хаагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүнийг дагаж мөрдөх журмыг таницуулах сургалтыг зохион байгууллаа.

Цэцэрлэгийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Сайн хичээл-Сайн технологи” үйл ажиллагааг 4 удаа зохион байгуулж 21 багш хичээл зааж “Хоёр Од-Нэг Хүсэл” гэсэн чиглэлээр хэлэлцүүлэг, бага боловсрол болон Байгалийн Ухааны судлагдахууны багаас "Математик 14 хоног" аяныг тус тус зохион байгууллаа.

Хүн амд эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ээлтэй орчинд чанартай хүртээмжтэй хүлээгдэл чирэгдэлгүй үйлчилж, сумын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний эмнэлзүйн удирдамжуудыг мөрдлөг болгон, яаралтай тусламжийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. 3-р сарын байдлаар амбулаторийн нийт үзлэг 1050, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 466/44,3%. Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, үйлчлүүлэгчийг эмчлэн эрүүлжүүлэх, оношинд тохирсон эмчилгээг заах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор мобайл технологийг нэвтрүүлэн түүний тусламжтай ард иргэдэд ШЕШ, ЭХО, ЗЦБ, Сахар, Шээсний хүчил үзэх, Холестерин үзэх, В, С вирус илрүүлэх зэрэг шинжилгээнүүдийг хийж үйлчилгээ үзүүлж байна.

Сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдад “Багшийн ёс зүйн харилцаа”, “ Хүүхэд хамгаалал”, “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”, “Багаар ажиллах” зэрэг сургалтыг зохион байгуулж, хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор 14 хоног бүр тестийн шалгалтыг авч мэдлэг чадварыг нь нэмэгдүүлэн ажиллаж байна. Эцэг, эх, багш, ажилчдын дунд Хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах хуулийн сургалт, сурталчилгааг явуулж, санамж гарган байршуулаад байна.

Дорнод аймгийн Матад суманд малын гоц халдварт “Шүлхий” өвчин илэрсэн тул сумын өвчлөмтгий үхэр, хонь, ямааг вакцинжуулах ажлыг түргэн шуурхай зохион байгуулж урьдчилан сэргийлээд байна. Вакцинжуулалтад сумын хэмжээнд үхэр 13624, хонь 87561, ямаа 54397 нийт 155582 толгой малыг хамрууллаа.

Түмэнцогт сумын сарын ажлын товч мэдээ:

Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн хичээллүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2019 оны А/17 тоот захирамжаар Засаг даргын нэрэмжит Ёпортын бага

наадмыг 3-р сарын 22-24-ний өдрүүдэд 6 төрлөөр зохион байгууллаа. Тус наадамд 24 байгууллагын 220 тамирчин оролцоо.

Аймгийн ИТХ-ын даргын санаачлан зохион байгуулсан “Агтан хүрээт” соёлын төслийн хүрээнд Дарьганга өв, соёлыг сурталчлах, нутгийн иргэдийн уламжлалт бүжгийн дэг, ардын урлагыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулж буй “Дарьгангын тойрог бүжиг”-ийг сумандаа зохион байгуулж 80 гаруй албан хаагчид хамрагдлаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн тэмдэглэн өнгөрүүлээ.

Сумын ЗДТГ, “Гэгээ” эмэгтэйчүүдийн бүлэг хамтран ардын дууны “Дүүриймаа” тэмцээн, Цэцэгт мэндчилгээ сэтгэлийн илгээмжийг 160 иргэдэд, сумын ИТХ, ЗДТГ, Хаан, Төрийн банк хамтран “Хуримтлалтай ээж” хэлэлцүүлэгийг тус тус зохион байгууллаа. Мөн Монгол цэргийн өдөр, Шинэ цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 98 жилийн ойн баярын арга хэмжээг тохиолдуулан Төрийн далбаа мандуулах ёслолын арга хэмжээ зохион байгуулж 50 гаруй албан хаагчдыг хамрууллаа.

Бүх нийтийн цэвэрлэгээг 20 гаруй байгууллагын 230 гаруй иргэдийн оролцоотой зохион байгууллаа.

Хууль, эрх зүйн ажлын төлөвлөгөөний дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Монгол хэлний тухай, Зар сурталчилгааны тухай, Өрсөлдөөний тухай гэх мэт хуулиар 30 гаруй иргэнд сургалт зохион байгуулж, худалдааны байгууллагын 50 гаруй ажилчдад гарын авлага, танилцуулга тараан мэдлэг шалгах бататгах зорилгоор АХА тэмцээн зохион байгууллаа.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх журмын дагуу үзлэг шинжилгээг сүүлийн 3 жилд тасралтгүй авч нийт 15,000 төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэн, эрүүл мэндийн төвд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Хэнтий аймгийн Баян-овоо сумын цэцэрлэг, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын цэцэрлэгийн багш ажилчидад сумын цэцэрлэгийн онцлог ажлууд болон тохижилт, хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөө, үйл ажиллагааныхаа талаар туршлагаа түгээн дэлгэрүүлж, санал бодлоо солилцлоо.

Цэцэрлэгийн багш, ээж, хүүхдүүдийн дунд “Монгол гоёл-2019” наадмыг 9 төрлөөр зохион байгуулж 23 хүүхэд хамрагдаж, уран ээжийг шалгарууллаа.

Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор багуудын засаг дарга нартай эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан малчин-даатгуулагчийн тэтгэвэр тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллаж 3-р сард 1 малчны тэтгэврийг тогтоосон.

Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаар 2 байгууллагын 76 ажилчин, албан хаагчдад сургалт зохион байгуулж, гар утасны апплейкшныг 6 иргэний гар утсанд суулган, 3 аж ахуйн нэгжид тоон гарын үсгээр тайлан илгээх үйлчилгээг нэвтрүүллээ.

Нийтийн эзэмшлий зам талбайг ногоон байгууламжтай болгох, нөхөн сэргээх зорилгоор “Ногоон байгууламж”, “Хог цэвэрлэгээ, сэг зэм устгах” зэрэг нийтийг хамарсан төсөл, “Хүнсний ногоо тарих” бүлгийн төсөлийг сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлөөр

хэлэлцүүлэн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйчилгээний газарт хүргүүлээд байна. Мөн ажлын байрыг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих болон ахмад настаны зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд иргэдээс 4 төсөл хүлээн авч, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйчилгээний газарт хүргүүлээд байна.

Бүртгэлтэй иргэдээс шинэ ажлын байраар хангагдсан 3 иргэн байна.

Хүүхдийн мөнгөтэй холбоотой ӨАТТСудалгаанд дахин хамрагдах хүсэлт гаргасан 3 өрхийн судалгааг авсан. Мөн ХЭБҮ-нд хамрагдсан 51 өрхийн 2-р сарын Хүнсний эрхийн бичгийг олголоо.

Өвөрмонголын сайн дурын бүлэг болох “Хайр халамж” wechat группын гишүүд зорилтот бүлгийн 28 өрхийн 13 өрхийн хүүхдэд болон гэр бүлийн гишүүдэд өвлийн хувцасны дэмжлэгийг 3 дахь удаагаа үзүүлж байна.

Монголжюаньли, Говь мастер ХХК-ны жонш тээвэрлэх замын чиглэл, маршрутыг тогтоож замын ашиглалт, хамгаалалтанд хяналт тавин ажиллаж байна.

Монголжюаньли ХХК-ны 3-р сард ашигласан усны бичилтийг хийж актыг үйлдсэн

Сумын төвд ийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 4га газрын хог хаягдлыг цэвэрлэж 20 тн хаягдал тээвэрлэж зайлуулсан

Ой хээрийн түймрээс хамгаалах түүнтэй тэмцэх төлөвлөгөөг гаргаж Засаг даргаар батлуулан, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага боловсруулан багуудийн засаг дарга нарт хүргүүлж өнөөдрийн байдлаар 120 иргэн 10 аж ахуйн нэгжид өгч гарын үсгийн баталгаа гаргуулан аваад байна

Малчин болон мал бүхий иргэдэд өвөлжөө хаваржааны хашаа хороог ариутгах халдваргүйжүүлэх талаар заавар зөвлөгөө өгөн, гарын авлага тарааж шүлхий өвчний урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг хийгээд байна.

Наран сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын сургалтыг төрийн албан хаагч нарт зохион байгуулж, сорлын шалгалт 65.8 хувийн дундаж үнэлгээтэй дүгнэгдлээ.

Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах талаар 3 удаагийн хурал хийж цаашид хийх ажлын төлөвлөгөөг батласан. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах зорилгоор фэйсбүүк групп нээж ажиллуулж байна.

3 дугаар сарын 07-нд сумын “Эмэгтэйчүүдийг зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа.

Сумын хэмжээнд мал төллөлт Үнээ 26%, Хонь 53%, Ямаа 58 хувьтай ба Адуу- 8, Үхэр-9, Хонь-256 , Ямаа- 250 нийт 523 төл малын хорогдолтой байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 8 иргэний 62,1 сая төгрөгийг төлүүлэх хугацаатай мэдэгдэл өгөөд байна.

Засаг даргын захирамжаар “Цэвэрч хот айл, өрх шалгаруулах” уралдааны журмыг гарган батлуулаад байна. Мөн Наранбулаг, Ширээ хавирга, Буруу хавирга, Хашаат, Сайнбулаг, Өлзийт булгийн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хашаа хайсыг янзлах төслийг бичиж Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, “Нэгдсэн хогийн цэгийг

цэгцлэх” төслийг бичиж аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлээд байна.

Төрийн сангийн программд шивсэн гүйлгээг баталгаажуулж төсөвт байгууллагуудын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа.

Хөрөнгийн дахин үнэлгээг хийж аймгийн Орон нутгийн өмчийн газарт 5 төсөвт байгууллагын 8 газар, 14 барилга, 6 байгууламж дахин үнэлсэн тухай материалыг хүргүүлээд байна.

Улсын Онцгой комиссын 01 тоот албан даалгавар, БОАЖСайд, Шадар сайдын хамтран гаргасан 12/А/51 тоот тушаал, аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврыг үндэслэн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай сумын Засаг даргын захирамж гарган мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг гарган, сумын Засаг даргаар батлууллаа.

Ерөнхий боловсролын 8,9-р ангийн сурагчдад мэргэжлийн багш нар “happy lesson” хичээлийг зохион байгуулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, илтгэл тавьлаа. Мөн Д.Шагдарсүрэн агсны нэрэмжит “Монгол хэл”-ний хичээлийн олимпиадыг 6,7-р ангиудын дунд зохион байгууллаа. ОУ-ын “Хүүхдийн эрхийг хамгаалах” өдрийг тохиолдуулан дунд ангийн сурагчдад оролцооны байгууллагын сурагчид хамтран “Хүүхдийн аюулгүй байдал” сэдэвт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж сурагчдын санал бодлыг сонсож хэлэлцүүлэг хийлээ.

“Хүүхэд-хэрэглэгч” аяны хүрээнд сурагчдын зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Хүүхэд хэрэглэгч аяны хүрээнд дунд ангийн багш нар ангидаа “Ухаалаг бүтээгдэхүүний зөв зохистой хэрэглээ”, “Хүнсний бүтээгдэхүүний зөв хэрэглээ”, “Хэрэглэгчийн эрх үүрэг” сэдвүүдээр мэдээлэл, сургалт хийж харилцан санал бодлоо солилцлоо.

9-р ангийн сурагчдаас Монгол хэл, Математик, Англи хэл, Физик гэсэн хичээлээр шалгалт авч эцэг эх, багш, сурагч, удирдлагуудаас санал асуулга авч материалыг битүүмжлэн явууллаа.

Насан туршийн боловсролын багш “Тогтвортой амжиргаа ба ногоон хөгжил” сэдвээр багш ажилчдад, “Эх дэлхийгээ хайрлая” сэдвээр цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн суралцагчдад мэдээлэл өглөө.

Цэцэрлэгийн багш, ажилчдын дунд “Сургалтын багц хэрэглэгдэхүүн” хийх уралдааныг зарлан шалгаруулаад байна. Дуу хөгжмийн ахмад багш М.Энххишиг цэцэрлэгийн хүүхдүүдэд бүжгийн элементийг зааж хамтран ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж буй хүүхдүүдийн дунд “Миний ээж хөөрхөн” хүүхдийн дууны уралдааныг зохион байгууллаа.

Соёлын төв олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Наран нутгийн бүсгүйчүүд тэмцээн, “Бүх хайрыг бүсгүйчүүдэд” тоглолт, “Ээждээ захидал бичээрэй” уралдаан, “Ээжтэйгээ хамт” селфи зургийн уралдаан, “Караоке” тэмцээн, “Хаврын найраг” тоглолтыг тус тус зохион байгууллаа.

Мөнххаан сумын сарын ажлын товч мэдээ:

Сумын төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн удирдах ажилтны зөвлөгөөний үеэр өгсөн үүрэг даалгаварыг 2019 оны үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг анхааруулж ажиллалаа. Мөн МУЗГ-аас 2019 оныг Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгон зарласантай холбогдуулан “Түмэнд ойрхон төрийн үйлчилгээ” гэсэн зорилтийг дэвшүүлэн, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сумын эмэгтэйчүүдийн зөвлөл, ЗДТГ хамтран “Замд гарья” мөсний баярыг зохион байгуулж, төсөвт 5 байгууллага, ХААН, Төрийн банк, 5-н багийн иргэд, аж ахуйн нэгжүүд гэсэн 13 багийн 200 гаруй хүн хамрагдлаа.

Мөнххаан уул, Баян-уул орчмын зам дагуух сэг зэм болон сумын төвийг тойрсон сэг зэмийн устгал, хог цэвэрлэгээг 4-5 хүний бүрэлдэхүүнтэй 2 хэсэг гарган, 94 бог, 8 бодын сэг зэм устгалын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хуурайшилтын улирал эхэлж байгаатай холбогдуулан Сумын засаг даргын захирамж гарган, аймгийн Засаг даргын албан даалгавар, Улсын онцгой комиссын 01 тоот албан даалгавар, БОАЖСайд, Шатар сайдын хамтран гаргасан 12/А/51 тоот тушаалыг 5-н багийн Засаг дарга нар, хэсгийн төлөөлөгч нарт танилцуулж, хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгоод байна. Мөн иргэдэд 300 ширхэг анхааруулах, санамж, гарын авлага материалыг тараагаад байна.

Байгаль орчны газраас зохион байгуулж буй уралдааны болзол журмыг иргэдэд сурталчилж, “Байгаль хамгаалах уламжлал” гар зургийн уралдаанд 6-н зураг, “Нэг удаагийн нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео уралдаанд 1 бүтээл явуулаад байна.

Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цогт хэмээх газарт зөвшөөрөлгүй худаг гаргах гэж байсныг зогсоож, Хунт-Өгөөж ХХК-ны усны тоолуурын заалтыг баталгаажууллаа.

Том малын хорогдол 3-р сарын 25-ны байдлаар адуу 24, үхэр 34, хонь 207, ямаа 170 нийт 435 толгой, мал төллөлт болон төл бойжилт 15-20% тай байна. Үлийн цагаан оготны тархалтын ажлаар ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Бямбасүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг ирж, сумын оготны тархалттай танилцаж, сумын удирдлагууд болон ХАА-н тасгийн мэргэжилтэн нартай мэдээлэл солилцон, хамтарч ажиллах талаар болон мэргэжил арга зүйн зөвөлгөө өглөө.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 45, зорилтот өрхийн 30 иргэнд 2 удаа сургалт зохион байгууллаа. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 6 иргэний төсөл, НХА-ын 1 төсөл, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийг хүлээн авч нийт 12 төслийг ХХҮГ-т хүргүүлээд байна.

Онгон сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, хууль сурталчилан зорилгоор төрийн мэдээллийн цагийг 1 удаа зохион байгууллаа.

МУЗГ-аас 2019 оныг Иргэн төвтэй төрийн үйлчилгээний ажил болгон зарласантай холбогдуулан Төрийн үйлчилгээг таны гэрт жил болгон зарлаж төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Соёлын төвөөс соёл, олон нийтийн үйл ажиллагаагааний төлөвлөгөөний дагуу зохион олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 03 сарын 07, 08 ны өдрүүдэд баярын хурал, хүндэтгэлийн тоглолт үдшийн цэнгүүнийг тус тус зохиож, Монгол цэргийн өдрөөр 2-р багийн малчин Б.Золжаргал, Ө.Даваа нар хамтран урлагын тоглолтыг хийлээ. Мөн 3 сарын 15 ны өдөр “Дуулах өдөр” ахмадын дуун цэнгүүнийг 1-р багийн ажлын алба, Ахмадын хороотой хамтран зохион байгууллаа.

Бүх нийтийн спортыг хөгжүүлэх, иргэдийг хичээллүүлэх зорилгоор сумын залуучуудын дунд гар бөмбөгийн тэмцээнийг залуучуудын холбоотой хамтран зохион байгууллаа.

Дарьганга сумын сарын ажлын товч мэдээ:

2019.03.12 ны өдөр аймгийн Засаг дарга суманд ажиллаж, иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг сонсч, мэдээлэл хийлээ.

Сумын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг тусгай удирдамжийн хүрээнд зохион байгуулж, 2018 оны ажлын тайлан, гарсан амжилт, зөрчил дутагдлаа ярилцаж, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, “Хариуцлагаа өндөрсгөж, амжилтаа бататгая” уриалга гаргасан ба зөвлөгөөний үеэр 4-н багийн Засаг дарга, 4-н төсвийн байгууллагын дарга нар сумын Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээ байгууллаа. Мөн “Сүхбаатарын өнгө” сонины нэг удаагийн дугаарт сумын 2018 оны үйл ажиллагааны тайланг нийтлүүлж, хамтран ажилласан бөгөөд 1000 ширхэг сонинг хэвлүүлж иргэдэд тараан, үйл ажиллагаагаа сурталчилан ажиллаж байна.

2019.03.25 ны өдөр “Эрх зүйн боловсролоо дээшлүүлье” сэдэвт сар бүрийн 25 нд иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлын нээлтийг хийхээр төлөвлөөд байна.

Сургуулийн эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулж харилцан ярилцаж зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан ажлаа эхлүүллээ. Мөн сургуулийн “Урлагийн үзлэг”-ийг тусгай удирдамжаар зохион байгуулж, шалгарсан хүүхдүүдийн “ГАЛА” тоглолтыг иргэдэд үзүүлж сонирхууллаа. Онгон, Түвшинширээ, Наран сумын багш нарын туршлага судлах уулзалтыг зохион байгуулж ажиллалаа.

Түүхэн болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгүүрллээ.

Монгол цэргийн баяр, Зэвсэгт хүчний 98 дахь өдөрт зориулсан Аймгийн ИТХ-ын төлөөлөгч П.Мөнхжаргалын шагайн зурхай нээлтийн үйл ажиллагаа, Дарьганга сумын шагай сонирхогчдын нээлттэй цуваа харваа тэмцээн 2019 оны 03 сарын 18-нд зохион байгууллаа. Мөн олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээжийн брэнд цай” өдөрлөгийг зохион байгууллаа.

“Мартаж болохгүй өв соёл” сэдэвт үйл ажиллагааг 2019.03.06 ны өдөр зохион байгуулж, олс, дээс, тэмээн утас томох тэмцээнийг 18-35 насны залуучуудын дунд зохион байгууллаа.

“Залуучуудын чуулга уулзалт”-ыг 18-35 насны залуучуудыг хамруулан анх удаа зохион байгуулж 100 гаруй залуус хамрагдан, “Залуус дуулж байна” дууны уралдаан зохион байгуулж, мэдээлэл солилцож, сумын удирдлагаас цаг үеийн мэдээлэл хийлээ.

Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллалаа.

“Тэмбүүгээс сэргийлэх аян”-ы хүрээнд сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулж аймгийн хэмжээнд тэргүүн байрт шалгарт 500,000 төгрөг, өргөмжлөлөөр шагнагдлаа.

Сумын Засаг даргын дэмжлэг, санаачилгаар “Хөдөлгөөнөөр эрүүлжцгээе” уриан дор Улаанбаатар хотын МНБСХолбооны багш, дасгалжуулагч С.Оюунцэцэг, бүжгийн багш Н.Амгалан нарыг урьж ирүүлэн 10 хоног иргэд, төрийн албан хаагчдад 16 бүжгийг заалгалаа. Нийт 140 төрийн албан хаагч, 40 гаруй иргэд хамрагдлаа.

Малын эрүүл мэндийг хамгаалах, урьчилан сэргийлэх тарилга хийгдэж эхлээд байна.

Аймгийн “Баялаг бүтээгчдийн холбоо”-оос 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг суманд ажиллаж, сумын баялаг бүтээгчидтэй уулзаж, харилцан зөвлөлдөж, зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.

Жил бүрийн олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр мартын 8 нд “Хоггүй хот айл”-ыг шалгаруулж, өргөмжилдөг уламжлалаар 2019 онд 4 эмэгтэйг шалгарууллаа.

Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Галба-өөш долоодойн говь сав газрын захиргаа хамтран Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Дарьганга сумын ЕБС-ын сурагчдын дунд “Усаа хэмнэе”, “Ус бол XI зууны алт” “Усны үнэ цэнэ” сэдвийн хүрээнд сургалт сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. Сургалтанд 6-9 дүгээр ангийн 90 орчим сурагчид хамрагдлаа. Мөн иргэд төрийн байгууллагуудын дунд “Элсэн цаг” танин мэдэхүйн тэмцээн уралдааныг зохион байгуулж, тэмцээнд 4 баг оролцсоноос ЗДТГ-ын “Н-2 О” баг 1-р байр, ЗДТГ-ын “Цэнгэг ус” баг 2-р байр, ЭМТ-ийн “Цэвэр ус” баг 3-р байрт шалгарлаа.

ЗДТГ-аас санаачлан, 1 дүгээр багийн Засаг дарга ахлан булаг шандны эхийг цэвэрлэх, сэг зэм устгалын ажлаар ГАШУУНЫ ГОЛ, ЦАГААН БУЛАГ, ХӨӨВРИЙН БУЛАГ, ХҮРМИЙН БУЛАГ, УЛААН НУУР, зэрэг газруудын сэг зэм болон орчиных нь хогийг цэвэрлэж нийт 80 адуу, 18 үхэр, 15 хонь, 6 ямааг устаглын цэгт хаялаа.

